6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	-	-	-	-
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	-	-	-	-
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	72.00	72.00	-	100.00
620001	Удирдах ажилтан	10.00	10.00	-	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	31.00	31.00	-	100.00
620003	Үйлчлэх ажилтан	31.00	31.00	-	100.00

3.Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Аймгийн Засаг даргын тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн шатахууны зардлын анхан шатны баримтын бүрдэл дутуу дээр зөвлөмж хүргүүлсэн.

Аудитыг 2022.02.21-нээс 2022.02.24-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2022.02.25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Өвөрхангай аймаг дахь төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Эрдэнэцэцэг хариуцаж хэрэгжүүлэв.

Тус байгууллага нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Өвөрхангай аймаг дахь төрийн аудитын газарт 2022.02.10-ны өдрийн 3/74 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Тус байгууллага нь “Оновчтой бодлого, зохицуулалтаар хангах замаар аймгийнхаа хөгжилд дэмжлэг үзүүлж чаддаг, цомхон, чадварлаг, эцсийн үр дүнг эрхэмлэн дээдэлсэн төрийн албыг төлөвшүүлэхэд оршино.” гэсэн эрхэм зорилготой.

Аймгийн ЗДТГазар нь үндсэн 6 хэлтэс, 2 албатай, 74 орон тоотой үйл ажиллагаагаа явуулж иржээ.

ЗДТГ-ын даргын тушаалаар 7 хүний бүрэлдэхүүнтэй дотоод хяналтын нэгж, 5 хүний бүрэлдэхүүнтэй ёс зүйн хороо, өмч хамгаалах байнгын комисс 5 бүрэлдэхүүнтэй төлөвлөгөө боловсруулан байгууллагын өмч хөрөнгийн хөдлөл өөрчлөлт, бараа материалын худалдан авалтад тухай бүр хяналт тавьж ажилладаг.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Аймгийн Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Аймгийн Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл

баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны нийт зардлын 17529.7 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 262.9 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 197.2 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Аймгийн Засаг даргын тамгын газрын 2021 оны үндсэн хөрөнгийн тодруулга тайлангаар 729.1 сая төгрөгийн хөрөнгө шинээр бүртгэлд тусгаснаас 180.1 сая төгрөгийн хөрөнгийг төсвийн хөрөнгөөр, 549.0 сая төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүйгээр хүлээн авч бүртгэлд тусгажээ. Нэмэгдсэн томоохон хөрөнгүүдийг дурдвал: 199.0 сая төгрөгөөр 2 авто машин, 260.0 сая төгрөгийн дотоод засвар, 117.5 сая төгрөгийн грашийн барилга зэрэг байна.

Тайлант онд 20.1 сая төгрөгийн тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, тавилга хэрэгслийг акталж, 180.7 сая төгрөгийн 2 авто машиныг бусад байгууллагад шилжүүлжээ.

Бараа материалын тодруулга тайлангаар 12,910.9 сая төгрөгийн багаа материал орлого авсны 265.5 сая төгрөгийн материалыг худалдан авсан, 9.2 сая төгрөгийн материалыг хандиваар авсан, 62.8 сая төгрөгийн материалыг шилжүүлэн авчээ.

Аймгийн ИТХ-ын шийдвэрийг үндэслэж аймагт хийгдсэн улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 12,573.3 сая төгрөгийн дуусаагүй барилгуудыг дуусаагүй үйлдвэрлэл дансанд бүртгэжээ. Бараа материалын тодруулга тайлангаар 11,092.2 сая төгрөгийн хасалт хийсний 204.6 сая төгрөг нь зардал, 10,880.6 сая төгрөг нь өмнөх онд дуусаагүй үйлдвэрлэл дансанд бүртгэлтэй байсан хөрөнгүүдийг хассан байна.

Авлагын тодруулга тайлангаар 5.3 сая төгрөгийн авлага, богино хугацаат өр төлбөрийн тодруулга тайлангаар 0.55 сая төгрөгийн өглөгийг тус тус тайлагнажээ.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуулийн хүрээнд 10.8 сая төгрөг төвлөрүүлсэн байна.

Тайлант онд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх үйл ажиллагаанд зориулан орон нутгийн төсвөөс 2,746.9 сая төгрөгийн санхүүжилт, өөрийн орлогоор 53.7 сая төгрөг, нийт 2,800.6 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 2,789.8 сая төгрөгийг урсгал үйл ажиллагааны зардалд зарцуулжээ.

Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт төсвийн дансаар 3,971.6 сая төгрөгийн санхүүжилт авч бараа үйлчилгээний бусад зардалд 2,663.9 сая, хангамж бараа материалын зардалд 482.4 сая, эд хогшил худалдан авахад 32.7 сая бусад зардалд 397.1 сая төгрөг зарцуулж, 395.5 сая төгрөгийг төвлөрүүлжээ.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Асуудлын онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэгт онцлон дурдах дараах зүйл байна.

-Цар тахлын нөхцөл байдалтай уялдуулж засаг даргын нөөц хөрөнгөнд тодотгол хийж, эх үүсвэрийг нэмэгдүүлж өгснөөр тайланд онд 932.3 сая төгрөгийн зарцуулалт хийжээ.

	Гэмт хэргээс урьд-н сэргийлэх арга хэмжээ	Ном хэвлэл нэвтрүүлэг сурталчилгаа/сурталт	Арга хэмжээ	Тусламж дэмжлэг	ӨВС Ховд	Шанал	Салбар/материал	КОВИД-19	Сургалт семинар	Онцгой, шуурхай шгас	Тээврийн хөлс	Тонг төхөөрөмж	90 жилийн ой	Цалин	Цэрэг татлага	Засвар хо	ӨВ Агро
Нөөц хөрөнгийн зарцуулалт /мян.төг/	7812.2	12424.2	126674	75192	18480	20958	4408.75	387925	11724.6	28673	6860	17537	10000	4186	18960	135739	45000

-Баянтээг ХК-ийн нийгмийн хариуцлагын хүрээнд олгосон дэмжлэгийг нэмэлт санхүүжилтийн дансаар хүлээн авч Засаг даргын А/500 дугаар захирамжаар 26 байгууллагад засвар үйлчилгээ, авто машин, тавилга, тоног төхөөрөмжийн санхүүжилтэд зарцуулжээ.

3.8 Аудитын гол асуудал

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 7 чиглэлээр аудитын 10 горим сорил гүйцэтгэсэн.

Материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ, үйл явдлыг аудитын гол асуудлыг тодорхойлоход харгалзаж үзсэн.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аймгийн Засаг даргын тамгын газар нь 2021 оны 4 дүгээр улиралд нийт 6,772.2 сая төгрөгийн 150 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулахаас 149 мэдээллийг ил тод мэдээлсэн, 1 мэдээллийн хугацаа болоогүй байна. 6 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны аудитаар бараа материалын тайлан гаргаагүй, цалингийн зардал болон нөөц хөрөнгөөс зориулалт бус зарцуулсан зэрэг 43.4 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, 1 зөвлөмжийг хүргүүлсэн. Албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг 2021.06.24-ний №2/277 дугаар бүхийн албан бичгээр нотлох баримтын хамт ирүүлсэн байна.

3.11 Аудитын үр өгөөжийн тооцоолол

Төлөвлөлтийн шатанд 10.0 сая төгрөгийн үр өгөөжийг төлөвлөсөн. Аудитаар 2021 оны санхүүгийн тайланд үндсэн хөрөнгө, урьдчилж гарсан зардал, бараа материал зэрэг 5,092.2 сая төгрөгийн хөрөнгө, эх үүсвэрийг тайланд тусгуулсан.

Дотоод хяналт, үйл ажиллагаагаа сайжруулснаар төсвийн хөрөнгийг үр дүнтэй зарцуулах, нөхцөл бүрдэнэ, Санхүүгийн тайланг стандартын дагуу үнэн зөв тайлагнаснаар тайлан хэрэглэгчид үнэн бодит мэдээллээр хангагдана. Хөрөнгөнд бүртгэлээр тавих хяналт бодитоор бий болж хөрөнгийн хадгалалт хамгаалалт сайжирна гэж санхүүгийн үр өгөөж тооцож, хүлээн зөвшөөрүүлсэн.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 5,243.2 сая төгрөгийн алдаа зөрчил илэрч 5,092.8 сая төгрөгийн алдааг аудитын явцад залруулсан. 150.4 сая төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага, 2 зөвлөмжийг хүргүүллээ.

4.1 Залруулсан алдаа

Аудитын явцад санхүүгийн тайланд дараах залруулгууд хийсэн.

- Аймгийн 90 жилийн ойд зориулан хэвлүүлсэн 16.2 сая, тэмдэг 15.0 сая, хөргөгчийн наалт 19.2 сая нийт 50.4 сая төгрөгийн хөрөнгийг бараа материалын тайланд орлого авхуулсан.
- Аймгийн 90 жилийн ойд зориулан хийлгэж байгаа баримтат киноны урьдчилгаанд олгосон 35.0 сая төгрөгийг урьдчилж гарсан зардлаар бүртгүүлсэн.
- Шагналд олгосон мөнгөнөөс суутгасан 0.6 сая төгрөгийн ХХОАТ-ыг төсөвт төлөөгүй байсныг өглөгөөр тусгуулсан.
- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдсан хүүхдийн эмнэлгийн барилгыг 4,889.3 сая төгрөгөөр дуусаагүй үйлдвэрлэл дансанд бүртгэсэн.
- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдсан ЗДТГ-ын грашийн барилгыг 117.5 сая төгрөгөөр үндсэн хөрөнгөд тусгуулсан.

4.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Зарцуулсан хөрөнгийн ашиглалт, үр дүнг сайжруулах талаар

1.1. Илрүүлэлт:

Нэмэлт санхүүжилт болон нөөц хөрөнгийн эх үүсвэрээс "ӨВ-Агро" ОНӨААТҮГ-ын үйл ажиллагаанд зориулж 220.7 сая төгрөгийн санхүүжилт олгосон, тухайн байгууллагын үйл ажиллагааны үр дүн тодорхойгүй, үйл ажиллагааны зардал давхар тайлагнагдсан байна.

1.2. Эрсдэл:

Хөрөнгийн өгөөж буурах, хууль, журам зааврыг мөрдөж ажиллаагүй байх.

1.3. Өгсөн зөвлөмж:

Зөвлөмж-1. "ӨВ-Агро" ОНӨААТҮГ-ын санхүүжилт авах төсөв, тооцоо, гэрээ, үйл ажиллагааны тайлан, үр дүнг тооцож үнэлэх.

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Асуудлын бүртгэлээр танилцуулсан.

2. Ажлын хариуцлагыг сайжруулах талаар

2.1. Илрүүлэлт:

Нэмэлт санхүүжилтийн дансаар орж ирсэн өвсний мөнгөний орлого, түүний зарцуулалт нь үндэслэх тоо баримтгүй, мөнгөн болон өвсний нөөц нь хэдий хэмжээний байгааг тодорхойлох тооцоо судалгаа байхгүй байна.

2.2. Эрсдэл:

Хөрөнгөд тавих хяналт сул, хууль, журам зааврыг мөрдөж ажиллаагүй байх.

2.3. Өгсөн зөвлөмж:

Зөвлөмж-2. Өвсний тооцоо судалгааг гаргаж, хариуцах байгууллага, албан тушаалтныг тодорхой болгож, ажлын хариуцлагыг сайжруулах.

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Асуудлын бүртгэлээр танилцуулсан.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

(сая төгрөгөөр)

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
	Аймгийн Засаг даргын тамгын газар	8	5,243.8	4	5,092.8			2	150.4	2	0

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

БЭЛТГЭСЭН: АХЛАХ АУДИТОР

О.БАТЖАРГАЛ

Д.ГАНСҮХ

Б.ЭРДЭНЭЦЭЦЭГ

2022 ОНЫ 02 ДУГААР САРЫН 25-НЫ ӨДӨР



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 011-2022/144/1А-СГА-ТУС/11560349/177 Арвайхээр

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГА Ц.ГАНБОЛД ТАНАА

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд нэмэлт санхүүжилтээс 11473.0 мянган төгрөгийн тавилга, 115000.0 мянган төгрөгийн авто машин худалдан авсан, ЗД-ын нөөц хөрөнгөөс боловсролын байгууллагын 100 жилийн ойн арга хэмжээ тэмдэглэхэд 23950.0 мянган төгрөг зарцуулсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.2.батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих;

Засгийн газрын 43 дугаар тогтоолын 1.4-д "... автомашин, албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, амралт, алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх" 1.6 "ЗГ-ын шийдвэр гарснаас бусад баяр ёслол, тэмдэглэлт ой, урлагийн наадам, спортын уралдаан тэмцээн...зэргийг зохион байгуулахгүй байх" гэсэн заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх, талаар байгууллага албан тушаалтанд албан шаардлага өгнө." Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11-д заасан "хууль, тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1.Дээр дурдсан зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажилласан тухай биелэлтийг 2022 оны 05 дугаар сарын 01-ний дотор Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Аймгийн ЗДТГазрын дарга Ц.Ганболд, нягтлан бодогч О.Цэрэнчимэд нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АХЛАХ АУДИТОР

О.БАТЖАРГАЛ
Б.ЭРДЭНЭЦЭЦЭГ





ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 18А-2022/44/НА-СТА-ТУС/11350349/176 Арвайхээр

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГА Ц.ГАНБОЛД ТАНАА

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд аймгийн ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансаар авч зарцуулсан зарим арга хэмжээнүүд нь хэтэрхий өргөн цар хүрээг хамарсан, зарцуулалтыг хянаж, тусдаа тооцоо судалгааг зайлшгүй хийх шаардлагатай ажил гүйлгээнүүд ихээр гарсан, бусад байгууллага, аж ахуйн нэгжид дамжуулан олгосон санхүүжилтийн шинжтэй ажил гүйлгээнүүд нь ТЕЗ-ийн нэгдсэн тайланд зардлыг давхар тайлагнагдах эрсдэлийг бий болгож, хөрөнгийн зарцуулалтад тавих хяналт суларсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.5.3."төсвийн гүйцэтгэл, зарцуулалт нь батлагдсан төлөвлөгөөний дагуу хэрэгжиж байгаа эсэхэд олон нийт хяналт тавих боломжоор хангах" 16.5.2.батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих; гэсэн заалтуудыг хэрэгжүүлээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх, талаар байгууллага албан тушаалтанд албан шаардлага өгнө." Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11-д заасан "хууль, тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Байгууллагуудад дамжуулан олгож байгаа санхүүжилт, хөрөнгө оруулалтын шинжтэй зардлуудыг аймгийн ЗДТГ-ын дансаар дамжуулан олгохыг хязгаарлах.
2. Зайлшгүй санхүүжүүлж байгаа төсөл арга хэмжээнүүдэд төсөв, тооцоо, ажлын гүйцэтгэлтэй уялдуулж хөрөнгийг зарцуулах.
3. Хөрөнгийн зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах ажлыг зохион байгуулж, биелэлтийг 2022 оны 05 дугаар сарын 30-ны дотор Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх;
4. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Аймгийн ЗДТГазрын дарга Ц.Ганболд, нягтлан бодогч О.Цэрэнчимэд нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АХЛАХ АУДИТОР

О.БАТЖАРГАЛ
Б.ЭРДЭНЭЦЭЦЭГ



Аудитаар илэрсэн алдаа зөрчлийн бүртгэлийн маягт

Аудитын код: ЭВА-2022/144/НА-СТА-ТШЗ

Аудитын нэр Санхүүгийн тайлангийн аудит
Байгууллагын нэр: Аймгийн Засаг даргын тамгын газар

№	Ажил гүйлгээний анги, дансны үлдэгдэл, тодруулга	2	3	4	5	6	7	Шалгагдагч байгууллагын	
								Албан тушаал	Овог нэр
А		Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн /сая/	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Шалгагдагч байгууллагын нэр, санал, тайлбар	Аудитын байгууллагаас өгсөн хариу, тайлбар	Гаргасан шийдэл	Албан тушаал	Овог нэр
1	Нийт зардал	Тайлант онд нэмэлт санхүүжилтээс 11473.0 мянган төгрөгийн тавилга, 115000.0 мянган төгрөгийн авто машин худалдан авсан, ЗД-ын нөөц хөрөнгөөс боловсролын байгууллагын 100 жилийн ойн арга хэмжээ тэмдэглэхэд 23950.0 мянган төгрөг зарцуулсан.	150.40	Албан шаардлага өгөх	Асуудлын бүртгэлээр танилцуулсан н.	Төсвийн тухай хуулийн 16.5.2 батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих; Засгийн газрын 43 дугаар тогтоолын 1.4-д, ... автомашин, албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, амралт, алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх", 1.6 "ЗГ-ын шийдвэр гарснаас бусад баяр ёслол, тэмдэглэлт ой, урлагийн наадам, спортын уралдаан тэмцээн...зэргийг зохион байгуулахгүй байх"	ЗГ-ын 43-р тогтоол болон холбогдох хууль журмыг мөрдөж ажиллах.	Дарга, Нягтлан бодогч	Ц.Ганболд, О.Цэрэнчимэд
2	Нийт зардал	Тайлант онд ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансаар авч зарцуулсан зарим арга хэмжээнүүд нь хэтэрхий өргөн цэр хүрээг хамарсан, зарцуулалтыг хянаж, тусдаа тооцоо судалгааг зайлшгүй хийх шаардлагатай ажил гүйлгээнүүд ихээр гарсан, мөн бусад байгууллага нэгжид дамжуулан олгосон санхүүжилтийн шинжтэй гүйлгээнүүд нь ТЭС-ийн нэгдсэн тайланд зардал давхар тайлагнагдах эрсдлийг бий болгож байна. Хөрөнгийн зарцуулалтад тавих хяналт суларсан байна.		Албан шаардлага өгөх	Асуудлын бүртгэлээр танилцуулсан н.	Төсвийн тухай хуулийн 6.3. "төсвийн гүйцэтгэл, зарцуулалт нь батлагдсан төлөвлөгөөний дагуу хэрэгжиж байгаа эсэхэд олон нийт хяналт тавих боломжоор хангах" 16.5.2 батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих.	1. Байгууллагуудад дамжуулан олгож байгаа санхүүжилт, хөрөнгө оруулалтын шинжтэй зардлуудыг ЗДТГ-ын дансаар дамжуулан олгох байдлыг хязгаарлах. 2. Зайлшгүй санхүүжүүлж байгаа төсөл арга хэмжээнүүдийн төсөв, тооцоо, ажлын гүйцэтгэлтэй уялдуулж хөрөнгийг зарцуулах. 3. Хөрөнгийн зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах.	Дарга, Нягтлан бодогч	Ц.Ганболд, О.Цэрэнчимэд

3	Нийт зардал	Нэмэлт санхүүжилт болон нөөц хөрөнгийн эх үүсвэрээс "ӨВ-Агро" ОНӨААТҮГ-ын үйл ажиллагаанд зориулж 220741.7 мянган төгрөгийн санхүүжилт олгосон, тухайн байгууллагын үйл ажиллагааны үр дүн тодорхойгүй, үйл ажиллагааны зардал давхар тайлагнагдсан байна.	Зөвлөмж	Асуудлын бүртгэлээр танилцуулсан н.	Төсвийн тухай хуулийн 6.5.3. төсвийн гүйцэтгэл, зарцуулалт нь батлагдсан төлөвлөгөөний дагуу хэрэгжиж байгаа эсэхэд олон нийт хяналт тавих боломжоор хангах; "Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 6.1 "Нөөц хөрөнгөөр хэрэгжүүлэх арга хэмжээг хариуцан гүйцэтгэж байгаа байгууллага, ажилтан хөрөнгийн зарцуулалтын тайланг арга хэмжээг хэрэгжүүлж дууссанаас хойш ажлын 15 хоногийн дотор гаргаж, тухайн шатны ЗДТГ-т ирүүлнэ".	Дарга, Нягтлан бодогч Ц.Ганболд, О.Цэрэнчимэд
4	Нийт зардал	Нэмэлт санхүүжилтийн дансаар орж ирсэн өвчний мөнгөний орлого, түүний зарцуулалт нь үндэслэх тоо баримтгүй, мөнгөн болон өвчний нөөц нь хэдий хэмжээний байгааг тодорхойлох тооцоо судалгаа байхгүй байна.	Зөвлөмж	Асуудлын бүртгэлээр танилцуулсан н.	Төсвийн тухай хуулийн 6.5.2. төсвийг төлөвлөх, бүрдүүлэх, хуваарилах, тайлагнах үйл ажиллагаанд олон нийтийн оролцоог хангах; НББ-ийн тухай хуулийн 13.7. Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно. 20.1.4. хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар эсхүл анхан шатны баримтаар баталгаажуулахгүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх.	Дарга, Нягтлан бодогч Ц.Ганболд, О.Цэрэнчимэд
Бэлтгэсэн: АХЛАХ АУДИТОР Анхан шатанд хянасан: АУДИТЫН МЕНЕЖЕР Хоёр дахь шатанд хянасан: ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР		Б.ЭРДЭНЦЭЦЭГ Д.ГАНСҮХ О.БАТЖАРГАЛ		Танилцаж зөвшөөрсөн: АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГИЙН ГАЗРЫН ДАРГА ЕРӨНХИЙ НИЯГЛАН БОДОГЧ		 